 - 16.1. If the Customer is in breach of any of these Terms including without limitation, a provision relating to the payment of money or if the Customer becomes subject to one of the following events: it suspends or threatens to suspend payment of its debts or is or becomes unable to pay its debts when they are due, or its financial position deteriorates to such an extent that in Sandvik's opinion the Customer's capability to adequately fulfil its obligations under the Contract has been placed in jeopardy, takes any step in connection with having any external manager or controller appointed (including any receiver, administrator, liquidator of any kind) or informs any person that it is, presumed to be, insolvent or if the Customer ceases or threatens to cease to carry on

- business or any guarantee or security given to Sandvik in relation to the Customer is revoked or unenforceable ("Insolvency Event") then Sandvik may, at its sole discretion, upon written notice to the Customer:
- 16.1.1. Immediately withdraw any purchase or credit facilities which may have been extended to the Customer and require immediate payment of all moneys owed to Sandvik by the Customer, whether or not they were due for payment in the future;
 - 16.1.2. Immediately suspend performance or terminate without penalty the Contract (including any license granted pursuant to Clause 11.2) in force between Sandvik and the Customer;
 - 16.1.3. Immediately take all possible action to protect its Goods and intellectual property rights; and/or
 - 16.1.4. Recover all costs and losses associated with such termination action.
 - 16.2. Termination (including pursuant to clause 2.3) shall be without prejudice to the accrued rights and liabilities of either party at the termination date.
 - 16.3. If a Force Majeure event prevents, hinders or delays a party's performance of its obligations for a continuous period of more than three (3) months, then either party may terminate this Contract by giving two (2) weeks' written notice to the other Party.
 - 16.4. Sandvik agrees to store and allow the Customer to download or otherwise retrieve, Customer specific Input Data and/or Output Data provided such request has been made to Sandvik in writing, and maximum thirty (30) days following the termination of the Contract.
- 17. General Provisions**
- 17.1. If a provision of these Terms is wholly or partly invalid or unenforceable in any jurisdiction, that provision or the part of it that is invalid or unenforceable must to that extent and in that jurisdiction be treated as deleted from these Terms. This does not affect the validity or enforceability of the remaining provisions.
 - 17.2. Nothing in these Terms is intended to exclude, restrict or modify rights which the Customer may have under any legislation to the extent it may not be excluded, restricted or modified by agreement.
 - 17.3. Except as otherwise expressed in these Terms, no right, power, privilege or remedy conferred is intended to be exclusive of any other right, power, privilege or remedy.
 - 17.4. The Customer shall comply at all times with the essence of the Sandvik Code of Conduct, a copy of which is available on request, and with all applicable laws, statutes and regulations, in particular those related to anti-bribery and anticorruption including the Criminal Code of Mongolia 2015, UK Bribery Act 2010 and the US Foreign Corrupt Practices Act as amended from time to time. Failure to comply with this paragraph shall constitute a material breach which will entitle Sandvik to terminate the Contract immediately.
 - 17.5. Sandvik may assign, novate or otherwise deal with the Contract pursuant to these Terms without the consent of the Customer, to the extent permissible by law. The Customer agrees to provide all assistance reasonably required by Sandvik to give effect to its rights under this clause.
 - 17.6. Except where prohibited by law, Customer shall require its insurer (if any) to waive all rights of subrogation against Sandvik and/or its insurers.
 - 17.7. A party waives a right under these Terms only if it does so in writing. A party does not waive a right simply because it fails to exercise the right, delays exercising the right or only exercises part of the right. A waiver of one breach of these Terms does not operate a waiver of another breach of the same term or any other term.
 - 17.8. Orders may be sent by e-mail or facsimile transmission. Any notice or demand must be in writing and shall be delivered by registered mail or by hand to the address set out in the Order, or sent by fax to its main fax number or sent by email to the address specified in the Order. If by registered mail, such notice or demand shall be deemed delivered 7 Days after the date of posting and, if sent by fax or email, at 9.00 am (Customer time) on the next business day after transmission.
 - 17.9. To the extent permitted by law, Sandvik is under no liability in respect of Goods exported without necessary licenses, authorisations or consents.
 - 17.10. No person who is not party to a Contract shall have any right to enforce any term of a Contract.
 - 17.11. Neither party shall cause, permit or tolerate an Unsafe condition or activity over which that party has control over. If a party observes or becomes aware of an Unsafe condition, that party may request the other party to remove or, to the extent reasonably possible, mitigate the effect of the Unsafe condition, and the other party must comply with that request. Sandvik reserves the right to suspend work under the Contract if Unsafe conditions exist, to which Sandvik's personnel (including but not limited to its directors, employees, contractors or subcontractors) may be exposed, until such time as the Unsafe conditions have been rectified. Unless the Customer can demonstrate that the Unsafe condition(s) have been rectified (and Sandvik did not cause the Unsafe condition or perform the Unsafe act), Sandvik is entitled to a reasonable extension of time for any delays caused by the Unsafe condition(s).
- 18. Governing Law & Dispute Resolution**
- 18.1. Any dispute arising out of or in connection with this Contract (including any question regarding its existence, validity or termination) shall be governed by English law.
 - 18.2. If either party determines there is any dispute or difference between them arising out of or in connection with this Contract (including interpretation of this Contract and conduct of the parties prior to this Contract) (in this clause called "**dispute**") then the party identifying the dispute must give written notice to the other party, detailing the dispute ("**Dispute Notice**").
 - 18.3. Within 14 Days of the Dispute Notice, each party must nominate a representative (with authority to resolve the dispute) and the representatives must meet at least once to attempt to resolve the dispute.
 - 18.4. If the parties have not resolved the dispute under clause 15.3, then within 28 Days of the Dispute Notice, a party may refer the dispute to the arbitration administered by the Singapore International Arbitration Centre ("**SIAC**") in accordance with the Arbitration Rules of the Singapore International Arbitration Centre ("**SIAC Rules**") for the time being in force, which rules are deemed to be incorporated by reference in this clause.
 - 18.5. The seat of the arbitration shall be Singapore, unless the Sandvik and the Customer mutually agree to another location, and the arbitration shall be conducted by a single arbitrator jointly selected by the parties, and in the event the parties cannot agree on the selection of the arbitrator within 35 Days from the Dispute Notice, an arbitrator shall be appointed pursuant to SIAC Rules. The language of the arbitration shall be English
 - 18.6. Despite the existence of a dispute under this clause, the parties must continue to perform their obligations under this Contract.
- 19. Prevailing language**
- 19.1. In the event of any discrepancy between the English and the Mongolian versions of these Terms, the English version shall prevail.

1. Тодорхойлолт ба Тайлбар

- 1.1. **"Төлбөрийн дүн"** гэж нэхэмжлэлд тусгагдсан төлөх шаардлагатай мөнгөн дүнгийн хэмжээг; **"Өдөр(үүд)"** гэж амралтын өдөр болон нийтээр тэмдэглэх баярын өдрүүдийг оролцуулсан хуанлийн бүх өдрийг; **"Гэрээ"** гэж Захиалга хүлээн авсан тухай бичиг, эдгээр Нөхцөлүүд, Үнийн санал, Захиалга болон Захиалга хүлээн авсан тухай бичиг, эдгээр Нөхцөлүүд эсхүл Үнийн саналд хавсаргасан эсхүл тэдгээрт иш татах замаар тусгагдсан аливаа бусад баримт бичгийг; **"Харилцагч"** гэж Сэндвикээс Бараа, Үйлчилгээ захиалсан этгээр болон аливаа зөвшөөрөгдсөн эрх хүлээн авагч этгээдийг; **"Хүргэлтийн өдөр"** гэж Гэрээнд заасан Бараа эсхүл Үйлчилгээг ханган нийлүүлэх өдрийг. **"Төлбөр төлөх өдөр"** гэж тоног төхөөрөмжийн тухайд нэхэмжлэх хүлээн авснаас хойш 7 өдөр, эд анги, богино хугацаанд элэгдэх бараа болон Үйлчилгээний тухайд нэхэмжлэл хүлээн авснаас хойш 30 өдрийг; **"Давагдашгүй хүчин зүйл"** гэж Сэндвикийн хяналтаас гадуур, үүнд цахилгаан эсхүл ус тасрах, үйлдвэрлэл, хүчин чадал эсхүл түүхий эдийн хомсдох, ажил хаялт, ажлын байрыг түр хаах, хөдөлмөрийн маргаан, гал түймэр, үер байгалийн гамшиг, нийгэмд аюултай терроризм, санаатай болон гэнэтийн шалтгаанаар үүссэн хохирол, тээвэрлэлтийн саатал, тоног төхөөрөмжийн эвдрэл, аливаа төр болон засгийн газрын чиг үүргийг хэрэгжүүлэгч байгууллагын хориг, хязгаарлалт болон худалдааны хориг, Сэндвик энэхүү Гэрээ болон хууль тогтоомжийг зөрчих эсхүл зөрчихөд хүргэж болзошгүй нөхцөл байдалд хүргэх Харилцагч болон гуравдагч этгээдийн үйлдэл, эс үйлдэл зэргийг оролцуулах боловч эдгээрээр хязгаарлагдахгүй аливаа үйл явдал болон нөхцөл байдлыг; **"Бараа"** гэж Захиалга хүлээн авах тухай бичигт Сэндвик ханган нийлүүлэхээр зөвшөөрсөн Захиалгад тусгасан барааг; **"Захиалга"** гэж Харилцагчийн зүгээс Бараа эсхүл Үйлчилгээний талаар (Харилцагчийн захиалгын хуудас нь Харилцагчийн аливаа нөхцөл, болзлыг иш татсан эсхүл дурдсан тохиолдолд эдгээр нөхцөл, болзлыг Сэндвик хүлээн зөвшөөрөхгүй бөгөөд тэдгээр нь энэхүү Гэрээний нэг хэсэг болохгүй) Сэндвикт хүргүүлсэн захиалгын хуудсыг; **"Захиалга хүлээн авах тухай бичиг"** гэж Сэндвик Захиалгыг хүлээн авах, улмаар Бараа нийлүүлэх эсхүл Үйлчилгээ үзүүлэх замаар эсхүл Харилцагчид "Захиалга хүлээн авах тухай бичиг" (эсхүл түүнтэй төстэй) нэртэй баримт бичгийг хүргүүлэх замаар Гэрээг хүлээн зөвшөөрөхийг; **"Хүргэлт хийснийг нотлох бичиг"** гэж Сэндвикийн Харилцагчид өгсөн хүргэлт хийснийг нотлох баримт бичгийг; **"Худалдан авагч"** гэж Сэндвикээс Бараа болон/эсхүл Үйлчилгээ захиалгагч этгээдийг хэлэх бөгөөд үүнд зөвшөөрөгдсөн эрх хүлээн авагч этгээдийг хамааруулна; **"Үнийн санал"** гэж Сэндвикээс Бараа эсхүл Үйлчилгээний талаар Харилцагчид өгсөн үнийн санал эсхүл саналын баримт бичгийг; **"Сэндвик"** гэж Захиалга хүлээн авах тухай бичигт тусгагдсан Сэндвик группийн аж ахуйн нэгжийг; **"Сэндвик групп"** гэж Сэндвик Маининг энд

Констракшин ЭйБи болон түүний шууд болон шууд бус өмчлөл эсхүл хяналтад байдаг бусад үйл ажиллагаа явуулж буй нэгдмэл сонирхолтой компаниуд болон охин компаниудыг; **"Барьцааны эрх"** гэж зээлдүүлэгч бусад этгээдээс тэргүүн ээлжинд хөрөнгийг борлуулсан орлогоос нэхэмжлэлийн шаардлагаа хангах боломжийг олгох аливаа барьцааны эрх (үүнд өмчлөх эрхээ хэвээр авч үлдэх, барьцаа болгож урьдчилгаа төлбөр төлөх эсхүл нөхцөл нөхөн төлөх урьдчилгаа эсхүл зөрчилтэй хөрөнгийн менежмент хамаарна) болон аливаа улсын хуулийн дагуу бүртгүүлж болох бүх барьцааны эрхийг; **"Үйлчилгээ"** гэж Захиалга хүлээн авах тухай бичигт тусгасан Сэндвикийн үзүүлэхээр зөвшөөрсөн Захиалгад дурдсан үйлчилгээг; **"Нөхцөлүүд"** гэж энэхүү Ханган нийлүүлэх нөхцөл болон болзлыг; **"Аюултай"** гэж аюулгүй байдал, эрүүл мэнд эсхүл байгаль орчинтой хамаатай хүлээн зөвшөөрөх боломжгүй учирсан эсхүл гарч болзошгүй аюул болон ослыг тус тус хэлнэ.

- 1.2. Эдгээр Нөхцөлд тухайн нөхцөл байдал өөрөөр тусгаагүйгээс бусад тохиолдолд, гарчиг нь зөвхөн мэдээлэх зорилготой бөгөөд тэдгээрийг тайлбарлахад нөлөөлөхгүй; дан тоо нь олон тоог илэрхийлэх ба олон тоо нь дан тоог илэрхийлнэ; баримт бичигт болон гэрээ гэдэгт тухай бүр тухайн баримт бичиг болон гэрээг хүчингүй болгож шинэчилсэн, өөрчилсөн, нэмэлт оруулсан эсхүл орлуулсан баримт бичиг болон гэрээ хамаарна. Этгээд гэсэн ишлэлд хувь хүн, нөхөрлөл, хуулийн этгээд, холбоо, төрийн болон орон нутгийн эрх бүхий байгууллага, агентлаг болон бусад этгээдүүд хамаарна; Хуулийн шаардлага болон бусад хууль гэдэгт тэдгээр хуулийн дагуу батлагдсан дүрэм, журам болон бусад баримт бичиг, мөн тэдгээрийг нэгтгэсэн, нэмэлт өөрчлөлт оруулсан, дахин баталсан эсхүл тэдгээрийг орлуулсан баримт бичгийг хэлэх ба ерөнхий утга илэрхийлсэн үг хэллэг нь "оролцуулан", "жишээ нь" эсхүл эдгээртэй адилхан илэрхийллээр илэрхийлсэн.
- 3.1. Харилцагчийн худалдан авалтын стандарт нөхцөл болон болзол; болон Энд дурдсанаас өөр нөхцөл болон болзол.
- 3.2. Харилцагч нь Сэндвикт өгсөн аливаа Захиалга нь Сэндвикээс Бараа эсхүл Үйлчилгээг энэхүү Нөхцөлийн дагуу худалдан авах захиалга болохыг болон Захиалга хүлээн авах тухай бичиг үйлдсэнээр Сэндвик болон Харилцагч нар нь энэхүү Гэрээний нөхцөлийг биелүүлэх үүрэгтэй гэдгийг хүлээн зөвшөөрч байна.
- 3.3. Бараа, Үйлчилгээ ханган нийлүүлэх гэрээг Захиалга хүлээн авах тухай бичиг үйлдсэнээр байгуулагдсанд тооцно.
- 3.4. Харилцагч нь Сэндвикээс аливаа Барааны эзэмшлийг хүлээн авах эсхүл аливаа Үйлчилгээний үр шимийг хүртсэнээр Бараа эсхүл Үйлчилгээ нь эдгээр Нөхцөлүүдийн нөхцөл болон болзлуудын дагуу ханган нийлүүлэгдсэн гэдгийг хүлээн зөвшөөрсөн гэж үзнэ.
- 3.5. Гэрээг бүрдүүлж буй хэсгүүд нь хоорондоо зөрчилдөж, үл нийцэж байгаа тохиолдолд, доорх эрэмбээр эрэмбэлэгдэнэ: 1. Эдгээр Нөхцөлүүд; 2. эдгээр Нөхцөлд хавсаргасан, иш татсан аливаа бусад баримт бичиг; 3. Захиалга хүлээн авах тухай бичиг; 4. Захиалга хүлээн авах тухай бичигт хавсаргасан, иш татсан аливаа бусад бичиг баримт; 5. Үнийн санал; 6. Үнийн саналд хавсаргасан, иш татсан аливаа бусад бичиг баримт; 7. Захиалга.
- 3.6. **Хүргэлт ба Эрсдэл**
Гэрээнд өөрөөр заагаагүй бол Сэндвик нь Захиалга хүлээн авах тухай бичигт заасан Сэндвикийн нэрлэсэн газар Ex Works (Инкотермс 2010 заасанчлан) нөхцөлөөр Барааг хүргэнэ. Бараанд холбогдох Эрсдэл Харилцагч руу Инкотермсийн

- дагуу 6.1-р зүйлд заасны дагуу шилжинэ. Хүргэлтийг нэг эсхүл түүнээс олон удаа хэсэгчлэн, өөр өөр хугацаанд эсхүл тусдаа ачаа тээвэрлэлт, хүргэлтээр хийж болно. Хүргэлтийн өдөр болон хүргэлтийн хугацааг Сэндвикийн Хүргэлт хийснийг нотлох бичигт зааснаар тодорхойлно.
- 4.2. Сэндвик нь Барааг Харилцагчийн хүргэлтийг хүлээн авах боломжгүй, чадваргүй болон хүсээгүй зэрэг шалтгааны улмаас Харилцагчид Хүргэлтийн өдөр хүргүүлэх боломжгүй болсон бол Сэндвик нь Харилцагчийн зардал болон эрсдэлээр аливаа Барааг өөрийн үзэмжээр хүргүүлэх эсхүл тэдгээрийг агуулахад хадгалах эрхтэй. Уг зардлыг шаардсан даруйд төлөх шаардлагатай бөгөөд энэхүү хариуцлага нь Харилцагчийн Барааг худалдаж авах үүрэг болон Сэндвикийн тухайн үүргийг зөрчсөнтэй холбогдуулан хохирлоо нэхэмжлэх эрхэд нөлөөлөхгүй болно.
- 4.3. Харилцагч нь Хүргэлтийн өдрөөс хойш 3-н сарын дотор Барааг хүлээн аваагүй тохиолдолд, Сэндвик нь өөрийн бусад эрхийг хөндөхгүйгээр Гэрээг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн цуцлах, Барааг захиран зарцуулах болон Харилцагчаас (i) Энгийн стандарт барааны тухайд худалдан авах үнийн дүнгийн 15%-ийг, (ii) Захиалгат барааны тухайд худалдан авах үнийн дүнгийн 30% эсхүл цуцалсан өдөр хүртэл гарсан түүхийг эд, хөдөлмөрийн хөлс хоёрын аль өндөр үнийн дүнг нэхэмжлэх эрхтэй бөгөөд Харилцагч нь Сэндвик уг үнийн дүнг нэхэмжилснээс хойш 10 өдрийн дотор төлбөрийг барагдуулна. Энэхүү зүйлийн дагуу Сэндвикт төлөх үнийн дүн нь Харилцагчийн Барааг хүлээн аваагүйгээс Сэндвикт гарах зардал болон алдагдлын бодит урьдчилан тооцоолсон дүн гэдгийг талууд хүлээн зөвшөөрч байна.
- 4.4. Сэндвик нь Харилцагчид өгсөн үйлчилгээ үзүүлэх хуваарийн дагуу Үйлчилгээг үзүүлнэ.
- 4.5. 4.6-р зүйлд зааснаас бусад тохиолдолд, Хүргэлтийн өдрийг шударгаар тооцон тогтоосон бөгөөд урьдчилсан тооцоолсон Хүргэлтийн өдөр эсхүл үйлчилгээ үзүүлэх хуваарийн дагуу ажиллахад зохих хүчин чармайлт гаргах хэдий ч Сэндвик нь аливаа Бараа эсхүл Үйлчилгээг хугацаанд нь ханган нийлүүлэхгүй эсхүл хугацаа хожимдуулснаас үүсэх аливаа хохирлыг хариуцахгүй. Түүнчлэн Харилцагчийн үйлдэл болон эх үйлдлийн улмаас Сэндвик энэхүү Нөхцөлүүдийн аль нэгийг биелүүлээгүйн улмаас учирсан аливаа алдагдлыг Сэндвик хариуцахгүй.
- 4.6. Сэндвик урьдчилан тохиролцсон хохирол хамаарна хэмээн Үнийн санал эсхүл Захиалга хүлээн авах бичигт тусгайлан заасан тохиолдолд Сэндвик Хүргэлтийн өдөр Бараа болон/эсхүл Үйлчилгээг ханган нийлүүлж чадаагүй бол Харилцагч Үнийн санал эсхүл Захиалга хүлээн авах бичигт заасан хэмжээгээр урьдчилан тохиролцсон хохирлыг нэхэмжлэх эрхтэй. Сэндвик Үнийн санал болон Захиалга хүлээн авах бичигт өөрөөр тусгайлан тохиролцоогүй бол Сэндвикийн аливаа Гэрээний дагуу хүлээх урьдчилан тохиролцсон хохирлын дээд хэмжээ нь доорх 4.7-р зүйлд заасан хэмжээний 5%-иас хэтрэхгүй.
- 4.7. Урьдчилан тохиролцсон хохирлыг зөвхөн хугацаа хожимдуулсан Бараа эсхүл Үйлчилгээний үнийн дүнгээс тооцож болно.
- 4.8. Харилцагч нь Хүргэлтийн өдрөөс хойш гурван сарын дотор уг хохирлыг бичгээр нэхэмжлээгүй тохиолдолд урьдчилан тохиролцсон хохирол авах эрхээ алдана.
- 4.9. 4.10-р зүйлд заасныг харгалзан эдгээр урьдчилан тохиролцсон хохирол нь Сэндвик Бараа болон/эсхүл Үйлчилгээг Хүргэлтийн өдөр хүргүүлээгүйгээс Харилцагчийн эдлэх хохирлоо барагдуулах цорын ганц арга хэмжээ юм.
- 4.10. Энэхүү зүйлийн дагуу төлөх урьдчилан тохиролцсон хохирол нь шийтгэлийн шинжтэй эсхүл хэрэгжих боломжгүй болсон тохиолдолд Сэндвикийн Харилцагчийн өмнө хүлээх хариуцлага нь хуулиар зохицуулагдах ердийн хохирол болно гэдгийг талууд хүлээн зөвшөөрч байна. Уг ердийн хохирлын хэмжээ нь Гэрээнд заасан урьдчилан тохиролцсон хохирол хэрэгжих боломжтой байсан бол төлөгдөх ёстой байсан урьдчилан тохиролцсон хохирлын хэмжээнээс ямар ч тохиолдолд хэтрэхгүй.
- 4.11. Давагдашгүй хүчин зүйл эсхүл Харилцагчийн үйлдэл болон эс үйлдэл үргэлжилж буй тохиолдолд Сэндвикийн энэхүү Гэрээний дагуу хүлээсэн үүргийн гүйцэтгэл нь түдгэлзэж, хугацаа түүний дагуу зохих ёсоор өөрчлөгдөнө.
- 4.12. Харилцагч нь Сэндвикт хүргэлтийг Харилцагч Хүргэлт хийснийг нотлох бичигт заасан өдрөөс хойш 7 өдрийн дотор бичгээр Барааны аливаа доголдол болон тоо хэмжээ дутуу талаар мэдэгдэх үүрэгтэй. Хэрвээ Харилцагч уг заасан хугацаанд Сэндвикт мэдэгдээгүй бол Харилцагчийг уг Барааг аливаа нөхцөлгүйгээр хүлээн авсан гэж үзнэ. Сэндвикийн бичгээр урьдчилан олгосон зөвшөөрөлгүйгээр Харилцагч нь Захиалгыг цуцлах эсхүл хойшлуулах эрхгүй.
- 4.13. Харилцагчид Гэрээнд үл нийцэх буруу ханган нийлүүлсэн бүхий л Барааны төлбөрийг бүхэлд нь буцаан олгоно. Сэндвикийн нэрлэсэн агуулах руу тээвэрлэх зардлыг Сэндвик бүрэн хариуцна. Хүргэлт хийснийг нотлох бичгээс хойш 21 өдрийн дотор буруу Бараа ханган нийлүүлсэн тухай мэдэгдлийг Сэндвикт хүргүүлэх бөгөөд ийнхүү мэдэгдээгүй тохиолдолд, Харилцагчийг тухайн Бараа хүлээн авсан гэж үзнэ.
5. **Харилцагчийн Буцаалт**
- 5.1. Харилцагчийн буцаах гэж буй доголдолгүй барааг Сэндвик нь зөвхөн Сэндвикийн бичгээр үйлдсэн урьдчилан олгосон зөвшөөрлийн дагуу Харилцагчаас хүлээн авна. Буцаалтаар хүлээн авсан бүх бараанд зохих үйлчилгээний зардлыг тооцно.
- 5.2. 4.13-р зүйлд зааснаас бусад тохиолдолд, 5.1 болон 12.2-р зүйлүүдийн дагуу бүх буцаасан Бараанд доорх нөхцөлүүд хамаарна. Үүнд:
- 5.2.1. Харилцагч нь Хүргэлт хийснийг нотлох бичигт заасан өдрөөс хойш 7 өдрийн дотор Сэндвикт мэдэгдэх үүрэгтэй;
- 5.2.2. мэдэгдэл хүлээн авсны дараа Сэндвик нь Барааг Сэндвикийн нэрлэсэн агуулахад хүргүүлэх заавар бүхий бичгээр үйлдсэн "Буцаалтын зааварчилгаа"-г явуулна;
- 5.2.3. Харилцагч нь тухайн Барааны Буцаалтын зааварчилгааны өдрөөс хойш 14 өдрийн дотор Сэндвикийн нэрлэсэн агуулахад буцаах үүрэгтэй;
- 5.2.4. Бусад нөхцөлийг үл харгалзан, буцаах боломжгүй зүйлд: Жийргэвч; Лац; Даруулга; Хоолой; Задалсан багаж хэрэгсэл; захиалгаар хийсэн эд зүйл; Сэндвикт хамааралгүй бараа; Шил орно.
- 5.3. Сэндвик нь Буцаалтын зааварчилгаа үйлдэх замаар урьдчилан бичгээр тохиролцсоноос бусад тохиолдолд Сэндвик нь буцаасан Бараанд ямарваа нэгэн үүрэг, хариуцлага эсхүл эрсдэл хүлээхгүй. Буцаалтын зааварчилгаа нь Барааг буцаахыг зөвшөөрсөн урьдчилсан зөвшөөрөл юм. Эцсийн бөгөөд бүхэлд нь хүлээн авах эсэхийг Сэндвик өөрийн үзэмжээр шийдвэрлэх бөгөөд энэ нь доорх нөхцөлөөс хамаарна:
- 5.3.1. Бараатай хамт Буцаалтын зааварчилгааны зөвшөөрлийн хуулбарыг ирүүлэх;
- 5.3.2. Барааг нэрлэсэн агуулахад хүлээн авахад биечлэн болон техникийн үзлэг хийгдсэн байх;
- 5.3.3. Буцаагдсан Бараа нь ямар нэгэн гэмтэлгүй, шинэ мэт дахин борлуулж болохуйц, үйлдвэрээс гарсан баглаа боодолтой (хэрэв байгаа бол) байх;
- 5.3.4. Барааг ямар нэгэн байдлаар суурилуулалт хийгдээгүй эсхүл бусад байдлаар ашиглагдаагүй байх;
- 5.3.5. Агуулахад хүргэгдсэн дээрх шаардлагыг хангаагүйн улмаас хүлээн авахаас татгалзсан Барааг Харилцагчаас зааварчилгаа өгөх хүртэл хугацаанд агуулахад хадгална;
- 5.3.6. 5.3.5-р зүйлийн дагуу хүлээн авахаас татгалзсан бөгөөд Харилцагч буцаан аваагүй Барааг Сэндвикийн нэрлэсэн агуулахад хүлээн авснаас хойш 3 сарын дотор буцаан аваагүй тохиолдолд тухайн Барааг устгана;
- 5.4. Барааг Буцаалтын зааварчилгааны өдрөөс хойш 14 өдрийн дотор, гэтлээ Сэндвикийн Хүргэлт хийснийг нотлох бичгийн өдрөөс хойш 30 өдөр өнгөрөөгүй тохиолдолд, Харилцагч нэхэмжилсэн үнийн дүнг бүхэлд нь авна. Хэрвээ Барааг Сэндвикийн Хүргэлт хийснийг нотлох бичгийн өдрөөс хойш 30 өдөр өнгөрсний дараа буцаасан бол Харилцагчид мөнгөн дүнг буцаан олгохгүй.
- 5.5. Буцаагдсан Барааг Сэндвикийн нэрлэсэн агуулахад хүргэх тээвэрлэлтийн зардлыг Харилцагч хариуцна.
6. **Үнэ ба Төлбөр**
- 6.1. Гэрээнд өөрөөр заагаагүй бол бүхий л үнэ нь Сэндвикийн Захиалга хүлээн авсан тухай бичигт хүргэхээр заасан Сэндвикийн хаягт Ex Work (Инкотермс 2010-ийн дагуу) нөхцөлөөр хүргэхээр санал болгосон үнэ байх бөгөөд тээвэрлэлтийн зардал, даатгал, татвар ороогүй болно. Хүргэлт хийхээс өмнө өөрчлөлт гарвал Сэндвик үнийн дүнг өөрчилж болно. Хэрвээ Харилцагч нь Бараа ханган нийлүүлэхээс эсхүл Үйлчилгээ үзүүлэхээс өмнө Захиалгаа өөрчлөх хүсэлт гаргавал, тухай хүсэлтийг Сэндвик өөрийн үзэмжээр хүлээн авах эсхүл татгалзах эрхтэй. Захиалга өөрчлөгдсөн тохиолдолд тухайн Захиалгын үнийн дүн (Тухайн тохиолдлоос хамааран) талууд харилцан

- тохиролцсоны дагуу нэмэгдэж, хасагдаж болох ба хэрвээ талууд тохиролцоонд хүрч чадаагүй тохиолдолд Сэндвикийн зохих үндэслэлтэйгээр үнийг тогтооно.
- 6.2. Сэндвик үнийн дүнг тогтоох тохиолдолд Сэндвикийн холбогдох тухайн зах зээл дэх үнийн жагсаалт, өртөг, зардал, алдагдал болон учирсан хохирол, ажлын байнаас гадуурх зардал, ашиг болон өөрчлөлттэй холбоотой бусад үндэслэл бүхий хөлс болон хураамж зэргийг харгалзан тогтооно.
- 6.2. Хэрэв Бараа болон/эсхүл Үйлчилгээний нийлүүлэлттэй холбоотойгоор аливаа нэг улсын хуулийн дагуу татвар төлөх шаардлагатай бол, тухайн татварыг үнийн саналын дүн дээр нэмж тооцно. Хэрэв Сэндвик нь тухайн татварыг суутгаж татварын алба эсхүл засгийн газрын эрх бүхий байгууллага руу шилжүүлэх ажлыг хариуцах тохиолдолд татвартай холбоотой нэмэлт үнийн дүнг Харилцагчид Бараа болон/эсхүл Үйлчилгээний үнийн дүнгийн нэхэмжлэлийн нэгэн адилаар, түүнтэй хамт хамт нэгэн зэрэг нэхэмжилнэ. Энэхүү Гэрээний дагуу гарсан эсхүл Гэрээтэй холбоотойгоор аль нэг талд төлөх төлбөрийг аливаа бусад дүн эсхүл орлогыг иш татан эсхүл тодорхой хувь хэмжээгээр тооцохоор заасан бол энэхүү төлбөрийг тухайн тодорхой дүн эсхүл орлогын иш татсан хэмжээгээр эсхүл түүний тодорхой хэмжээгээр татварыг оролцуулахгүйгээр тооцж болно.
- 6.3. Хэрэв Сэндвикээс Харилцагч эсхүл түүний томилсон тээвэрлэгч этгээд Барааг авч, хилээр тээвэрлэн гаргах ажлыг хариуцна гэсэн үндэслэлээр Сэндвик нь Харилцагчаас татвар нэхэмжлээгүй тохиолдолд Харилцагч нь ийнхүү хүсэлт гаргаснаар түүнээс хойш хоёр долоо хоногийн дотор Сэндвикд тухайн Бараа нь нэг улсаас нөгөө руу шилжсэн гэдгийг нотлох бүх баримт бичгийг Сэндвикт гаргаж өгнө. Хэрвээ Харилцагч нь эсхүл түүний томилсон тээвэрлэгч этгээд нь тухайн Барааг хил даван шилжилт хийгдсэн гэдгийг нотлох баримт бичгийг хүлээлгэж өгөөгүй бол Харилцагч нь Сэндвикийн тухайн Барааны нийлүүлэлттэй холбоотойгоор татварын албаны эсхүл засгийн газрын эрх бүхий байгууллагын оногдуулсан бүх татвар, торгууль, алдангийг Сэндвикд төлнө.
- 6.4. Гэрээнд өөрөөр заагаагүй бол Сэндвик нь Харилцагчид Бараа эсхүл Үйлчилгээг ханган нийлүүлснээр нэхэмжлэх болно. Харилцагч нь Төлбөрийн дүнг Төлбөр төлөх өдөр эсхүл түүнээс өмнө аливаа суутган тооцох, суутгал болон хорогдолгүйгээр бүрэн төлнө. Хэрвээ Харилцагч нь хуулийн дагуу ямар нэгэн татвар суутгах шаардлагатай бол Сэндвик тухайн төлбөртэй холбогдуулан татвар суутгаагүй бол эсхүл бусад байдлаар төлөгдөх ёстой байсан эсэхээс үл хамааран авах ёстой байсан төлбөрөө авах явдлыг хангах үүднээс Харилцагч нь нэмэлт төлбөрийг Сэндвикт төлнө. Харилцагч нь Төлбөр төлөх өдөр Төлбөрийн дүнг төлөөгүй тохиолдолд Сэндвик нь Төлбөр төлөх өдрөөс төлбөрийг бүрэн төлөх хүртэл хугацаанд хугацаа хэтэрсэн Төлбөрийн дүнгээс сарын 1.5%-ийн хүү эсхүл түүний хэсгийг нэхэмжилж нөхөн төлүүлэх эрхтэй. Харилцагчаас төлсөн мөнгөн дүн нь бүрэн төлөгдсөн эсхүл үнийн дүнг бүрэн барагдуулсан тохиолдолд хүчин төгөлдөр гэж үзнэ.
- 6.5. Харилцагчийн Төлбөр төлөх өдөр төлөөгүйгээс Сэндвикд үүссэн хууль зүйн үйлчилгээний зардал болох өмгөөлөгчийн хууль зүйн үйлчилгээний зардал, хариуцлагаас чөлөөлөх зарчмын дагуу өр барагдуулах зардал болон өр барагдуулах агентлагийн эсхүл бусад ижил төрлийн байгууллагын зардал зэрэг хамаарах боловч зөвхөн эдгээрээр хязгаарлагдахгүй бүх төрлийн зардлыг бүрэн хариуцаж, Сэндвикийг хариуцлагаас чөлөөлнө гэдгийг Харилцагч хүлээн зөвшөөрч байна.
- Өмчлөх эрх**
- 7.1. Сэндвикийн Харилцагчид борлуулсан болон хүргүүлсэн Барааны өмчлөх эрх нь Барааны Төлбөрийн дүнг бүрэн төлөгдөх (үүнд 6-р зүйлийн дагуу төлөгдөх бүхий л хуримтлагдсан хүү (хэрэв байгаа бол)) хүртэл Харилцагчид шилжихгүй.
- 7.2. Сэндвикийн борлуулсан болон хүргүүлсэн Барааны өмчлөх эрх Харилцагчид 7.1-р зүйлийн дагуу шилжих хүртэл:
- 7.2.1. Харилцагч нь тухайн Барааг өөрийн эзэмшлийн бусад Бараанаас тусад нь байлгана;
- 7.2.2. Харилцагч нь өөрийн түрээсэлдэг тухайн Бараа хадгалж буй аливаа газрын түрээслүүлэгчид тухайн Бараа нь Сэндвикийн өмч болохыг мэдэгдэнэ.
- 7.3. Энэхүү гэрээ болон холбогдох хуулийн дагуу Сэндвикийн эдлэх эрхээс гадна, Төлбөр төлөх өдөр Төлбөрийн дүнг төлөөгүй Барааг буцаан авах үүднээс Сэндвик нь Харилцагчийн эзэмшлийн талбайд (үүнд түрээсийн талбай хамаарна) хэдийд ч нэвтрэн орох эрхтэй (Хуулиар зөвшөөрсөн хүрээнд). Сэндвик нь Барааг өөрийн эзэмшилдээ буцаан авах зорилгоор харилцагчийн эзэмшлийн талбайд нэвтэрсэн бөгөөд Харилцагчийн эзэмшлийн Барааны өмчлөлийг тогтоох боломжгүй тохиолдолд, Харилцагчийн Барааг хүлээн авсан дарааллын дагуу Бараануудыг борлуулсан гэж үзнэ гэдгийг талууд харилцан тохиролцсон болно. Хэрвээ тухайн Бараануудын тоо ширхэг өр төлбөрөөс хэтэрсэн тохиолдолд, Сэндвик нь тухайн бараануудаас аль барааг өмчлөх эрхтэйг тогтоох эрхтэй.
- 7.4. Харилцагч нь тухайн Барааны эрсдэл Харилцагчид шилжсэнээс хойш өмчлөх эрх өөрт нь шилжих хүртэл хугацаанд тухайн Бараатай ижил төрлийн бараанд хамаарах бүхий л эрсдэлийн эсрэг тухай бүр даатгуулна. Хэрэв Сэндвик шаардсан тохиолдолд Харилцагч нь тухайн Барааны даатгалын гэрээний хуулбарыг гаргаж өгөх үүрэгтэй.
- Баталгаа**
- 8.1. Захиалга өгөх өдрийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж буй Сэндвик Майнинг энд Рок Технологи-ийн стандарт баталгаа нь Сэндвикийн ханган нийлүүлсэн Бараанд хамаарах бөгөөд Захиалган хүлээн авах тухай бичгийн хамт Харилцагчид өгнө.
- 8.2. 8.1-р зүйл хамаарахгүй тохиолдолд Сэндвикийн ханган нийлүүлсэн Бараа нь зохих ёсоор ашигласан тохиолдолд материал болон хийцийн хувьд доголдолгүй бөгөөд 3-н сарын хугацаанд Гэрээнд заасан шаардлагад нийцнэ гэдгийг Сэндвик баталж байна. Энэхүү 8-р зүйлд “зохих ёсоор ашиглах” гэж Сэндвикийн холбогдох баримт бичгийн дагуу суурилуулсан, ашиглалтад оруулсан, ажиллуулсан болон засвар үйлчилгээ хийснийг, “Доголдол” гэж материал болон хийцийн хувьд согогтой болон/эсхүл дутуу орхигдсон болон Гэрээнд аливаа байдлаар нийцээгүйг тус тус хэлнэ. Харилцан өөрөөр тохиролцоогүй бол Сэндвик ямар ч тохиолдолд аливаа гуравдагч этгээдийн ханган нийлүүлсэн болон үйлдвэрлэсэн эд анги болон бүрэлдэхүүн хэсэгт баталгаа өгөхгүй.
- 8.3. 14.2-р зүйлд заасанчлан, 8.1 болон 8.2-р зүйлүүдэд өгсөн баталгаа нь тусгайлан заасан, далд утга бүхий эсхүл хуульд заасан, үүнд чанарын шаардлага хангасан, тодорхой зориулалтын шаардлага хангасан тухай зэрэг аливаа бусад баталгаа, нөхцөл болон Бараатай холбогдуулж үйлдвэрлэгчээс нэхэмжлэх шууд бус эсхүл бусад алдагдлын эсрэг авах эрх сэргээх арга хэмжээний оронд өгч буй баталгаа болно. Сэндвик бичгээр тусгайлан баталгаа өгснөөс бусад тохиолдолд ямар нэгэн тусгайлан заасан эсхүл дулд утга бүхий баталгаа өгөөгүй болно.
- 8.4. Сэндвик нь хуульд заасны дагуу хүлээх хариуцлагаа хязгаарлах боломжгүй тохиолдолд энэхүү 8-р зүйлийн дагуу Сэндвикийн хүлээх үүрэг нь тухайн аливаа доголдол бүхий Барааг солих эсхүл засварлах замаар доголдлыг арилгахын аль нэг сонголт, харин Үйлчилгээний тухайд үйлчилгээг дахин үзүүлэх зардлаар хязгаарлагдана. Аливаа баталгаатай холбоотой нэхэмжлэлийг Харилцагч нь зөвхөн Баталгааны хүчинтэй хугацаанд бичгээр гаргана.
- Барьцааны Эрх**
- 9.1. Сэндвик энэхүү Гэрээнээс үүдэлтэй гэж үзэж буй Барьцааны эрхийг холбогдох хуулийн дагуу барьцааны эрхийг бүртгэх эрх бүхий Монгол Улсын холбогдох төрийн байгууллагад бүртгүүлэх эрхтэй.
- 9.2. Харилцагч нь доорхыг хүлээн зөвшөөрч байна:
- 9.2.1. Сэндвикийн Барааны Барьцааны эрх (9-р зүйлд заасанчлан) нь Гэрээний дагуу Харилцагчийн Сэндвикт төлөх ёстой бүхий л үнийн дүнг төлөх баталгаа болно.
- 9.2.2. Сэндвикийн Барьцааны эрх нь Барааг борлуулснаас олох бүхий л орлогод хамаарна.
- 9.3. Харилцагч нь доорх зорилгоор Сэндвикээс шаардсан бүхий л үйлдлийг (Харилцагчийн зардлаар) нэн даруй гүйцэтгэх (үүнд бие даасан барьцааны гэрээ байгуулах, Барьцааг бүртгүүлэхтэй холбоотойгоор итгэмжлэл олгох, зөвшөөрөл авах, баримт бичигт гарын үсэг зурах, бусад этгээдээр гарын үсэг зуруулах, мэдээллээр хангах болон барьцааны эрхтэй бусад этгээдтэй дэд гэрээ эсхүл эрхийн дараалал тогтоох гэрээ байгуулах зэрэг) хийж гүйцэтгэнэ гэдгийг Харилцагч хүлээн зөвшөөрч байна. Үүнд:
- 9.3.1. Гэрээнээс үүссэн Барьцааны эрхийг баталгаажуулах эсхүл бусад хэлбэрээр хүчин төгөлдөр болгох;
- 9.3.2. Сэндвикийн барьцааны эрхтэй холбогдох бүхий л эрхийг хэрэгжүүлэхэд туслалцаа үзүүлэх.
- 9.4. Хэрэв Харилцагч нь Бараанд Барьцааны эрх эзэмшиж байгаа бол Харилцагч нь доорхыг хэрэгжүүлэхэд шаардлагатай

- бүхий л арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг хүлээн зөвшөөрч байна. Үүнд:
- 9.4.1. тухайн Барьцааны эрхтэй холбогдуулан аль болох тэргүүн ээлжинд эрхээ хангуулах дарааллыг хангах, үүнд барьцааны эрхийг эрх бүхий Монгол Улсын төрийн байгууллагад бүртгүүлэх хамаарах боловч зөвхөн үүгээр хязгаарлагдахгүй болно.
- 9.4.2. Гуравдагч этгээдийн Сэндвикийн Барьцааны Барьцааны эрх болон Харилцагчийн барьцааны эрхгүйгээр эсхүл Харилцагчийн Барьцааны эрхээс тэргүүн ээлжинд Бараанд хамаарах эрхийг олж авах эрсдэлийг аль болох бууруулах.
- 9.5. Сэндвик Барааны Барьцааны эрхээ хэрэгжүүлэх аливаа эрхэд тухайн Бараанд хамаарах бүхий л оюуны өмчийн эрхийг хэрэгжүүлэхийг Харилцагч хүлээн зөвшөөрч байна.
- 9.6. Харилцагч нь Бараанд хамаарах бусад Барьцааны эрх эзэмшигчээс тухайн Барьцааны эрхтэй холбоотой аливаа мэдээллийг авах болон тийнхүү авахыг зөвшөөрч Сэндвикийг өөрийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилж байна. Шаардлагатай тохиолдолд Харилцагч нь энэ асуудлаар Сэндвикт итгэмжлэл олгоно.
- 9.7. Шаардлагатай тохиолдолд Сэндвик нь Гэрээний тодорхой эрх эсхүл бүрэн эрхийг хэрэгжүүлэх эсэхээ шийдвэрлэнэ.
- 9.8. Хуулиар зөвшөөрөгдсөн хэмжээнд Барааны өмчлөх эрх эдгээр Нөхцөлүүдийн дагуу Харилцагчид шилжих хүртэл Харилцагч нь тухайн Бараанд ямар нэгэн нэмэлт нэмэх эсхүл суурилуулах эсхүл Барааг ямар нэгэн зүйлд суурилуулахгүй эсхүл бусад зүйл нэмэхгүй гэдгийг хүлээн зөвшөөрч байна.
- 10. Нууц Мэдээлэл**
- 10.1. Харилцагч нь Сэндвикээс зээл авах хүсэлт гаргасан тохиолдолд Сэндвик Харилцагчийн зээл хүсэх өргөдлийг үнэлэхэд шаардлагатай гэж үзсэн зохих лавлах ажиллагааг хийхийг хүлээн зөвшөөрч, эрхийг нь олгож байна. Мөн Харилцагч Сэндвикт хуулиар зөвшөөрөгдсөн хүрээнд хувийн мэдээлэлтэй холбоотой аливаа зүйлийг зээлийн мэдээллийн эрх бүхий байгууллагад өгч, мөн Харилцагчийн зээлийн мэдээллийг батлан дааж байгаа эсхүл батлан даах гэж байгаа этгээдүүдэд зээл төлөх чадварын талаар мэдээллийг өгч болохыг Харилцагч хүлээн зөвшөөрч, ийнхүү эрхийг олгож байна.
- 10.2. Сэндвикийн нууц мэдээлэлтэй холбоотой журмыг (тухай бүр нэмэлт өөрчлөлт орсон) Гэрээний талууд дагаж мөрдөх үүрэгтэй. Сэндвикийн журам нь ямар ч төрлийн мэдээлэл дамжуулах сүлжээгээр (үүнд цахим сүлжээ хамаарна) нийтлэгдэж болох бөгөөд Харилцагч нь зохих ёсоор Сэндвикт хүсэлт гаргасан тохиолдолд Сэндвик өгч болно.
- 11. Оюуны Өмч**
- 11.1. Сэндвик доорхын цорын ганц өмчлөгч бөгөөд өмчлөгч хэвээр үлдэнэ. Үүнд:
- 11.1.1. Бараа эсхүл Үйлчилгээнд холбогдох бүхий л оюуны өмчийн эрх.
- 11.1.2. энэхүү Гэрээний гүйцэтгэлээс үүссэн бүхий оюуны өмчийн эрх.
- 11.2. Захиалга хүлээн авах тухай бичиг үйлдэгдэж болон Бараа эсхүл Үйлчилгээний төлбөрийг бүрэн төлж дууссан тохиолдолд Сэндвик нь Харилцагчид онцгой бус, бусдад шилжүүлэх боломжгүй, эрх шилжүүлэх боломжгүй, бусад ашиглуулах боломжгүй Сэндвикийн Бараа, Үйлчилгээнд хамаарах эсхүл түүнтэй дагалдах оюуны өмчийг ашиглах лицензийг тухайн Бараа эсхүл Үйлчилгээг суурилуулах, ажиллуулах, засвар үйлчилгээ хийхэд шаардлагатай хэмжээнд олгоно. Бичгээр өөрөөр заагаагүй бол энэхүү хязгаарлагдмал эрхтэй лиценз нь эдгээр Нөхцөлүүдийн дагуу цуцлагдаагүй тохиолдолд хүчин төгөлдөр хэвээр үргэлжилнэ.
- 11.3. Харилцагч нь Сэндвикийн бичгээр урьдчилан өгсөн зөвшөөрөлгүйгээр Бараа эсхүл Үйлчилгээг бүтнээр эсхүл хэсэгчлэн дахин үйлдвэрлэх, өөрчлөх, шинэчлэх, тохируулалт хийх, хөрвүүлэх, задлан шинжлэх эсхүл аливаа дагалдах бүтээгдэхүүн гаргах эрхгүй.
- 11.4. Сэндвик Бараа болон Үйлчилгээнээс гарах бүхий л мэдээллийг цуглуулах болон хадгалах эрхтэй бөгөөд Харилцагч түүнийг цуглуулахад шаардлагатай нөвтрэх эрх олгохыг хүлээн зөвшөөрч байна.
- 11.5. Сэндвик нь өөрийн бараа болон үйлчилгээний өгөөж, эд ангийн хүргэлт болон бүтээгдэхүүний худалдан авалтын дараах үйлчилгээг сайжруулах, шинэ бүтээгдэхүүн гаргах зэрэг бизнесийн зорилго болон бусад бизнесийг сайжруулах зорилгоор өөрийн цуглуулсан болон хадгалсан аливаа мэдээллийг ашиглах эрхтэй.
- 12. Хариуцлага**
- 12.1. Хуулиар зөвшөөрөгдсөн хүрээнд гэрээний аль тал нь гэрээний нөгөө талд шийтгэлийн шинжтэй эсхүл цэвэр эдийн засгийн зардал, шууд бус, дагалдах, онцгой эсхүл шууд бус алдагдал эсхүл хохирол; эдийн засгийн алдагдал, алдагдсан боломж, үйлдвэрлэлийн алдагдал, ашиглалтын алдагдал, борлуулалтын алдагдал, нэр хүнд алдагдсанаас үүссэн алдагдал, ашгийн алдагдал эсхүл олох ёстой байсан ашгийн алдагдал эсхүл орлогын алдагдал зэрэг урьдчилан тооцоолох боломжтой байсан эсэх болон тухайн талд хэрхэн бий болсон эсэхээс үл хамаарах түүнд учирсан буюу гарсан эсэхээс үл хамааран, жишээ нь энэхүү Гэрээг нөгөө тал зөрчсөн, гэм хор учруулсан эсхүл хууль бус үйлдэл, эс үйлдэл (үүнд Хайхрамжгүй байдал хамаарна), шударга ёсны зарчмын дагуу, хуулиар хүлээсэн үүрэг, хариуцлагыг биелүүлээгүй болон бусад байдлаар (аль нэг тал тухайн алдагдал эсхүл хохирлыг урьдчилан тооцоолох боломжтой байсан эсэхээс үл хамаарна) үүссэн эсэхээс үл хамаарах хариуцлагыг хүлээхгүй. Сэндвикийн дээрх хязгаарлагдсан хариуцлагатай холбогдуулан аливаа асуудлаар гуравдагч этгээдийн Сэндвикийн эсрэг гаргасан аливаа нөхэмжлэлийг Харилцагч бүрэн хариуцаж, түүнийг үүргээс бүрэн чөлөөлнө.
- 12.2. Хуулиар зөвшөөрөгдсөн хүрээнд Сэндвик нь ямар ч үед Сэндвикийн энэхүү Гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн, Сэндвикийн гэм хор учруулсан эсхүл хууль бус үйлдэл болон эс үйлдэл (Үүнд Хайхрамжгүй байдал хамаарна), шударга ёсны зарчмын дагуу эсхүл Сэндвик хуулиар хүлээсэн үүрэг, хариуцлагыг гүйцэтгээгүй эсхүл бусад байдлаар үүссэн эсэхээс үл хамааран Сэндвикийн Харилцагч болон энэхүү Гэрээгээр хүлээсэн үүрэг, хариуцлагыг хүлээн зөвшөөрч, тухайн бичгийн бусад этгээдийн өмнө хүлээх хариуцлага нь Захиалга хүлээн авах тухай бичгийн дагуу төлсөн үнийн дүгийн 100%-с хэтрэхгүй болно. Харин энэхүү 12.2-р зүйл нь Сэндвикийн Харилцагчид тухайн Захиалга хүлээн авах тухай бичигтэй холбоотойгоор учирсан амь нас эсхүл эрүүл мэндэд учирсан хохирол эсхүл эд хөрөнгийн хохиролд хүлээн хариуцлагаас чөлөөлөх эсхүл хязгаарлах зорилгогүй болно.
- 13. Цуцлалт**
- 13.1. Харилцагч нь эдгээр Нөхцөлүүдийн аль нэгийг зөрчсөн үүнд төлбөр төлөх тухай заалт эсхүл Харилцагч өр төлбөрөө төлөхөө зогсоосон эсхүл зогсоохоор төлөвлөж байгаа эсхүл хугацаа нь болоход төлбөрөө төлөх чадваргүй болсон эсхүл хөндлөнгийн менежер эсхүл хяналт тавих этгээд (үүнд аливаа эрх хүлээн авагч, хэрэг гүйцэтгэгч, татан буулгагч эсхүл түүнтэй адилтгах этгээд хамаарна) томилогдсон, аливаа этгээдэд төлбөрийн чадваргүй болсон гэж мэдэгдсэн, эсхүл Харилцагч нь бизнесийн үйл ажиллагаагаа зогсоосон эсхүл зогсоохоор төлөвлөж байгаа, эсхүл Сэндвикт өгсөн Харилцагчийн баталгаа эсхүл барьцаа хүчингүй болсон эсхүл хэрэгжих боломжгүй болсон зэрэг тохиолдолд Сэндвик өөрийн үзэмжээр Харилцагчид бичгээр мэдэгдсэний үндсэн дээр:
- 13.1.1. Харилцагчид олгосон худалдан авах эсхүл зээлийн эрхээс нэн даруй татгалзаж, Харилцагчаас Сэндвикт төлөх шаардлагатай төлбөрийг ирээдүүд төлөх ёстой байсан эсэхээс үл хамаарч нэн даруй төлөхийг шаардах.
- 13.1.2. Сэндвик болон Харилцагчийн хооронд байгуулсан хүчин төгөлдөр үйлчилж буй аливаа Гэрээний хэрэгжилтийг ямар нэгэн хариуцлага хүлээхгүйгээр зогсоох эсхүл цуцлах (үүнд 11.2-р зүйлийн дагуу олгосон аливаа лиценз хамаарна).
- 13.1.3. Бараа болон оюуны өмчийн эрхийг хамгаалах бүхий л арга хэмжээг нэн даруй авах.
- 13.1.4. Тухайн цуцлахтай холбоотой гарсан аливаа зардал болон алдагдлыг нөхөн төлүүлэх.
- 13.2. Цуцлалт нь талуудын цуцлах өдрийг хүртэлх хугацаанд хуримтлагдсан аль нэг талын эрх, үүрэгт нөлөөлөхгүй (үүнд 2.3-р зүйл нэгэн адил хамаарна).
- 14. Нийтлэг Зүйлс**
- 14.1. Эдгээр Нөхцөлүүдийн аль нэг зүйл нь аль нэг улсад хэсэгчлэн болон бүхэлдээ хүчин төгөлдөр бус эсхүл хэрэгжих боломжгүй бол тухайн зүйл эсхүл түүний хэсэг нь тухайн хэмжээгээр уг улсад түүнийг байхгүй байсан мэт тооцогдоно. Энэ нь бусад зүйл заалтын хүчин төгөлдөр байдал, хэрэгжилтэд нөлөөлөхгүй.
- 14.2. Эдгээр Нөхцөлийн аль нэг заалт нь Харилцагчийн гэрээгээр үйлчлэхгүй болгох, хязгаарлах эсхүл өөрчлөх боломжгүй хуулиар олгогдсон эрхийг үйлчлэхгүй болгох, хязгаарлах эсхүл өөрчлөх зорилгогүй болно.
- 14.3. Эдгээр Нөхцөлүүдэд өөрөөр заагаагүй бол аливаа эрх, бүрэн эрх, давуу байдал эсхүл эрх сэргээх арга хэмжээ нь бусад эрх, бүрэн эрх, давуу байдал болон эрхээ сэргээх арга хэмжээг орлох зорилгогүй болно.

- 14.4. Харилцагч нь Сэндвикийн Үйл ажиллагааны журам болон холбогдох бүхий л хууль, дүрэм, журмыг, тэр дундаа тухай бүр нэмэлт өөрчлөлт орох хээл хахууль болон авлигын эсрэг хууль тогтоомж үүнд 2015 оны Монгол Улсын Эрүүгийн хууль, Их Британийн Авлигын тухай хууль, АНУ-ын Гадаад Авлигын эсрэг хууль (зөвхөн эдгээр хуулиар хязгаарлагдахгүй болно) зэргийг байнга дагаж мөрдөнө. Уг заалтыг дагаж мөрдөөгүй нь гэрээний ноцтой зөрчилд тооцогдож Сэндвикт Гэрээг нэн даруй цуцлах эрх үүснэ.
- 14.5. Сэндвик нь хуулиар зөвшөөрөгдсөн хүрээнд, Харилцагчийн зөвшөөрөлгүйгээр эдгээр Нөхцөлийн дагуу энэхүү Гэрээг шилжүүлэх, хүчингүй болгож гуравдагч этгээд шинээр байгуулах болон бусад хэлбэрээр зохицуулах эрхтэй. Харилцагч нь энэхүү зүйлд заасан эрхээ хэрэгжүүлэхэд нь Сэндвикт шаардлагатай зохих бүхий л туслалцааг үзүүлнэ гэдгээ хүлээн зөвшөөрч байна.
- 14.6. Аль нэг тал эдгээр Нөхцөлөөр олгогдсон эрхээс зөвхөн бичгээр үйлдсэн тохиолдолд л татгалзана. Тал нь зөвхөн эрхээ хэрэгжүүлээгүй, эрхээ хойшлуулж эдэлсэн эсхүл хэсэгчлэн хэрэгжүүлсний төлөө тухайн эрхээс татгалзсанд тооцогдохгүй. Эдгээр Нөхцөлүүдийн нэг зөрчлөөс татгалзсан нь адил нөхцөл эсхүл бусад нөхцөлийн зөрчлөөс татгалзсанд тооцогдохгүй.
- 14.7. Цахим шуудангаар болон факсаар ирүүлсэн Захиалгаас бусад тохиолдолд аливаа мэдэгдэл эсхүл шаардлагыг бичгээр Захиалгад дурдсан хаягаар, албан ёсны бүртгэлтэй шуудангаар эсхүл биечлэн хүргүүлнэ. Албан ёсны бүртгэлтэй шуудангаар илгээсэн мэдэгдэл эсхүл шаардлагыг түүнийг илгээсэн өдрөөс хойш 7 өдрийн дараа түүнийг хүргүүлсэн гэж үзнэ.
- 14.8. Нууцын шинжийг агуулсан Харилцагчид задруулсан эсхүл Харилцагч олж авсан ханган нийлүүлсэн Бараа болон Үйлчилгээнд холбогдох бүхий л мэдээллийн нууцлалыг Харилцагч хадгална гэдгийг хүлээн зөвшөөрч байна. Тухайн мэдээлэл нь ямар ч үед Сэндвикийн өмч байна.
- 14.9. Хуулиар зөвшөөрөгдсөн хэмжээнд Сэндвик нь тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл болон эрхийн бичиггүйгээр экспортлсон Бараанд үүрэг хариуцлага хүлээхгүй.
- 14.10. Гэрээний тал биш этгээд энэхүү Гэрээний аль ч нөхцөлийг биелүүлэхийг шаардах эрхгүй.
- 14.11. Гэрээний нэг тал нь өөрийн хяналт хэрэгжүүлэх боломжтой Аюултай нөхцөл байдал болон үйлдлийг гаргах, гарахыг зөвшөөрөх эсхүл хүлцэн тэвчихгүй. Гэрээний аль нэг тал нь Аюултай нөхцөл байдлын талаар мэдсэн тохиолдолд, тухайн нөхцөл байдлыг арилгах эсхүл боломжтой бол үр нөлөөг багасгахыг нөгөө талаас хүсэх бөгөөд гэрээний нөгөө тал нь энэхүү хүсэлтийг биелүүлэх үүрэгтэй. Сэндвикийн ажилтнууд (төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, ажилтан, гэрээт ажилтан туслан гүйцэтгэгчид үүнд хамаарах боловч зөвхөн эдгээрээр хязгаарлагдахгүй) өртөж болзошгүй Аюултай нөхцөл байдал бий болсон тохиолдолд, тухайн аюултай нөхцөл байдлыг арилгах хүртэл, Сэндвик Гэрээний дагуу гүйцэтгэх ажлыг зогсоох эрхтэй. Тухайн Аюултай нөхцөл байдал (Сэндвик нь Аюултай нөхцөл байдлыг бий болгоогүй эсхүл аюултай үйлдэл хийгээгүй) арилсан гэдгийг Харилцагч нь нотлох хүртэл Аюултай байдлаас үүссэн аливаа хугацааны хоцрогдлыг Сэндвик үндэслэл бүхий хугацаагаар сунгуулах эрхтэй.
- 15. Зохицуулах хууль болон Маргаан шийдвэрлэх**
- 15.1. Энэхүү Гэрээ болон гэрээний зүйл, гэрээ байгуулсан эсэх, түүний хүчин төгөлдөр байдал болон цуцлах (Гэрээний бус маргаан болон нэхэмжлэл үүнд хамаарна)-тай холбоотой нэхэмжлэлийг Англи улсын хуулийн дагуу шийдвэрлэнэ.
- 15.2. Хэрэв аль нэг тал энэхүү Гэрээ (Гэрээг тайлбарлах болон талуудын Гэрээг байгуулахаас өмнөх үйлдэл үүнд хамаарна)-тэй холбоотой маргаан болон саналын зөрүү гарсан гэж үзвэл (Энэхүү зүйлд **"Маргаан"** гэнэ) уг маргааныг тодорхойлогч тал нь маргааны талаарх мэдэгдлийг нөгөө талдаа бичгээр өгнө (цаашид **"Маргааны тухай мэдэгдэл"** гэнэ).
- 15.3. Тал тус бүр Маргааны тухай мэдэгдлээс хойш 14 өдрийн дотор төлөөлөгч (Маргааныг шийдвэрлэх эрх бүхий) томилох бөгөөд эдгээр төлөөлөгчид нь нэгээс доошгүй удаа маргааныг шийдвэрлэх зорилгоор уулзсан байна.
- 15.4. Хэрэв талууд 15.3-р зүйлд заасны дагуу маргааныг Маргааны тухай мэдэгдлээс хойш 28 өдрийн дотор шийдвэрлэж чадаагүй тохиолдолд, аль нэг тал маргааныг Сингапурын Олон Улсын Арбитрын төвийн (**"СОУАТ"**)-д тухай үед хүчин төгөлдөр мөрдөгдөж буй энэхүү зүйлд иш татан оруулсан гэж үзэх Сингапурын Олон Улсын Арбитрын Төвийн Дүрэм (**"СОУАТ-ийн Дүрэм"**) дагуу шийдвэрлэхээр хандаж болно.
- 15.5. Сэндвик болон Харилцагч арбитрын хуралдаан явуулах газрыг харилцан өөрөөр тохиролцоогүй бол арбитрын хуралдаан Сингапур улсад явагдах бөгөөд талууд хамтран сонгох нэг арбитрч маргааныг шийдвэрлэх бөгөөд Маргааны тухай мэдэгдлээс хойш 35 өдрийн дотор арбитрчийг сонгоогүй тохиолдолд арбитрчийг СОУАТ-ийн Дүрмийн дагуу томилно. Арбитрын ажиллагаа Англи хэл дээр явагдана.
- 15.6. Энэхүү зүйлийн дагуу маргаан гарсан эсэхээс үл хамааран талууд Гэрээгээр хүлээсэн үүргээ үргэлжлүүлэн гүйцэтгэх үүрэгтэй.
- 16. Баримтлах Хэл**
- 16.1. Эдгээр Нөхцөлүүдийн Англи болон Монгол хэл дээрх хувилбар хооронд зөрүү гарсан тохиолдолд Англи хэл дээрх хувилбарыг дагаж мөрдөнө.